

ААБ 5.5: АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АЛДАА, ЗӨРЧИЛТЭЙ АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: **САЙНЦАГААН СУМЫН ТТЗ**


Тайланг хугацаа: 2024.03.24

№	Ажил Гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулга	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	Аудитын байгууллагаас өгсөн харну тайлбар	Гаргасан шийдэл	Шалгагдагч байгууллагын холбогдох хүний	
								Албан тушаал	Овог нэр
А	1	3	4	5	6	7	8	9	10
1	Орлогын данстай холбоотой асуудал	Нийт 13 нэр төрлийн татварын орлогоос 5 нэр төрлийн татварын орлогыг батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу төвлөрүүлсэн	143,468,323.00	Албан шаардлага хүргүүлэх	Орлогын төлөвлөгөөг өндрөөр баталснаас татварын орлого тасарсан	Орлогыг бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх	Албан шаардлага хүргүүлсэн	Дарга, Санхүүгийн албаны дарга	С.Бат-Оргил, Б.Уранжаргал
Нийт дүн			143,468,323.00						

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ж.УТГАХБАЯР

Х.НАРАНЦАЦРАЛ

Р.МӨНХТОГТОХ

ЗАСАГ ДАРГА

САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

Б.УРАНЖАРГАЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА С.БАТ-ОРГИЛ
ТАНАА

2024-03-25 № 114

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 841.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 23.4 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн 6.3 сая төгрөгийн гүйлгээ хийж зарцуулсан, Орон нутгийн хөгжлийн сан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй хийлгэсэн зэрэг зөрчлүүд нь тайлант үеийн эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт, 36 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 98.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/10/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дундговь аймаг 2024 он</p>	<p>Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Д.Ихбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn</p> <p>Аудитор: Ж.Угтахбаяр Утас: 70593113 Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	6
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	7
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	7
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	8
4. Аудитын тайлан	9
4.1 Ерөнхий зүйл.....	9
4.2 Материаллаг байдал.....	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
5. Аудитын илрүүлэлт.....	11
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Булгийн удирдлагын өрөөн, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Улс, 70592439, 70592208,
70593208, Хаягч хаяг: dundgovi.audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН САЙНЦАГААН
СУМЫН ЗАСАГ ДАРГА С.БАТ-ОРГИЛ
ТАНАА

2024-08-25 № 114
нийслэл _____ нийслэл № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг харкцуцлагыг биелүүлж ажилласан. Бидний пуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 841.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч, 23.4 сая төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлж авсан байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газар нь анхан шатны баримтыг хуурамчаар бүрдүүлэн 6.3 сая төгрөгийн гүйлгээ хийж зарцуулсан, Орон нутгийн хөгжлийн сан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлээгүй, хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлгүй хийлгэсэн зэрэг зөрчлүүд нь тайлант үеийн эрсдэл өндөр үнэлэгдсэн асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 10 зорилт, 36 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 98.7 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,947,121.3	2,394,416.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	555,383.5	1,034,301.3
33	АВЛАГА	999,794.4	991,391.7
35	БАРАА МАТЕРИАЛ	315,453.4	292,233.9
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	76,490.0	76,490.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,355,304.2	2,821,145.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,355,304.2	2,821,145.6
39200	Биет хөрөнгө	2,162,967.2	2,623,866.6
39300	Биет бус хөрөнгө	192,337.0	197,279.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	4,302,425.5	5,215,562.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	7,678.1	11,416.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,678.1	11,416.9
41300	Өглөг	7,678.1	11,416.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,294,747.4	5,204,145.6
51	Засгийн газрын хувь оролцоо	4,294,747.4	5,204,145.6
51100	Засгийн газрын оруулсан капитал	677,666.3	677,666.3
51200	Хуримтлагдсан үр дүн	3,508,862.0	4,418,260.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	108,219.0	108,219.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,302,425.5	5,215,562.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,364,050.6	7,506,333.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,909,533.9	5,130,253.6
110	Орлогын албан татвар	3,437,984.3	4,684,278.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,437,984.3	4,684,278.3
113	Хөрөнгийн албан татвар	167,656.4	224,227.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	303,893.3	221,748.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	850,790.6	1,486,536.2
120	Нийтлэг татварын бус орлого	850,790.6	1,486,536.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	603,726.2	889,543.5
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,830,472.1	5,855,203.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,830,472.1	5,855,203.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,279,153.8	1,868,678.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	486,663.0	769,658.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,076.0	95,449.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,173.0	66,479.4
2104	Хангамж, бараа материалын зардал	249,153.2	127,219.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,467.9	26,385.0
2107	Томилолт, зочны зардал	4,935.5	6,158.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	115,994.0	121,902.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	299,691.3	655,425.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,551,318.2	3,986,525.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	533,578.6	1,651,129.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,191,059.7	735,507.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)	-17,657,481.2	915,622.6

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	22,180,906.6	22,180,906.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-228,678.1	-228,678.1

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,952,228.5	21,952,228.5
9	Тайлант үеийн үр дүн	-17,657,481.2	-17,657,481.2
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,294,747.4	4,294,747.4
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,294,747.4	4,294,747.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-6,224.4	-6,224.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,288,523.0	4,288,523.0
19	Тайлант үеийн үр дүн	915,622.6	915,622.6
20	2023 оны 12-р сарын 30-наарх үлдэгдэл	5,204,145.6	5,204,145.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Мян.төг/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,540,678.0	7,161,030.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,909,533.9	5,130,253.6
110	Орлогын албан татвар	3,437,984.3	4,684,278.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	3,437,984.3	4,684,278.3
113	Хөрөнгийн албан татвар	167,656.4	224,227.3
118	Бусад татвар, төлбөр, хураамж	303,893.3	221,748.0
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	118,242.0	117,936.1
1181	Газрын төлбөр	123,743.2	103,461.9
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	61,908.0	350.0
1183	Бусад татвар	0.0	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,034,064.5	1,154,945.0
120	Нийтлэг татварын бус орлого	1,034,064.5	1,154,945.0
121	Хөрөнгийн орлого	0.0	0.0
122	Тусламжийн орлого	0.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	597,079.6	875,832.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,521,869.4	5,435,597.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,521,869.4	5,435,597.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,860,011.3	3,003,707.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	837,255.4	769,933.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	101,655.3	95,449.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,467,742.1	66,479.4
2104	Хангамж, бараа материалын зардал	50,396.7	83,560.9
2105	Нормативт зардал	240.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	101,006.4	35,333.0
2107	Томилолт, зочны зардал	4,935.5	6,158.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	121,565.8	1,673,454.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	175,214.0	273,339.1
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,661,858.1	2,431,890.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,018,808.6	1,725,433.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	801,556.6	898,515.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	801,556.6	898,515.2
2200	Дотоод эх үүсвэрээр	801,556.6	898,515.2
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-801,556.6	-898,515.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-515,000.0	-348,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	515,000.0	348,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-297,748.1	478,917.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	853,131.6	555,383.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	555,383.5	1,034,301.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мян.төг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,043,689.90	4,210,943.05	832,746.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,387,848.40	3,055,670.15	332,178.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,331,578.40	3,015,886.00	315,692.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,270.00	39,784.15	16,485.85
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	999,841.50	807,272.91	192,568.60
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	656,000.00	348,000.00	308,000.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,043,689.90	4,414,977.36	628,712.54
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	793,841.50	793,841.50	-
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,450,848.40	3,118,225.18	332,623.22
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	799,000.00	502,910.68	296,089.32
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-
62	АЖИЛЛАГААНЫ ТОО	44.00	44.00	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДААР)	0.00	0.00	-
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	0.00	0.00	-
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	0.00	0.00	-
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	0.00	0.00	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	0.00	0.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.00	44.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Мян.төг/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	81,990.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	81,990.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	72,566.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,424.19
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	81,990.47
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо “Иргэдийн оролцоотойгоор хэрэгцээнд суурилсан сумын урт хугацааны хөгжлийн бодлогыг төлөвлөх, орон нутгийнхаа нөөц боломжид тулгуурлан хөгжих, бизнесийн таатай орчин бүрдүүлж, өрсөлдөх чадвар, бүтээмжийг дээшлүүлэх бодлогыг цогц баримт бичгийн байдлаар тодорхойлоход оршино” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, дотоод аудитыг ТЕЗ-ийн харьяа Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хэрэгжүүлсэн байна. Байгууллагын дотоод хяналтын зөвлөлд санхүүгийн мэргэжилтэй албан хаагч байхгүйгээс зөвхөн үндсэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалтын эрсдэлийг л тооцож байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилгот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүждэг байсан Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төвүүдийн байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, мөнгөн гүйлгээний тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд тайлагнасан байна.

3.4.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 913,137.0 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, өмчийн данс байна.

Хүснэгт №1.

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	555,383.5	1,034,301.3	478,917.8
Авлага	999,794.4	991,391.7	(8,402.7)
Бараа материал	315,453.4	292,233.9	(23,219.5)
Нөөцийн бараа	76,490.0	76,490.0	-
Үндсэн хөрөнгө	2,355,304.2	2,821,145.6	465,841.4
Нийт хөрөнгө	4,302,425.5	5,215,562.5	913,137.0
Ор төлбөр	7,678.1	11,416.9	3,738.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,294,747.4	5,204,145.6	909,398.2
Ор төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,302,425.5	5,215,562.5	913,137.0

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 478,917.8 мянган төгрөгөөр өссөн нь татварын орлого давж биелсэн, өмнөх оны үлдэгдлийг зарцуулахаар төсөвт нэмж тавьснаас шалтгаалсан байна. Авлага дансны нийт үлдэгдлийн 94 хувийг хоршоо хөгжүүлэх сангийн авлага эзэлж байна. Үндсэн хөрөнгө данс 465,841.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь МСҮТ-ийн барилгын их засварыг ЗДТГ-ын хөрөнгөнд бүртгэсэн, хандив болон худалдан авсан үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой байна.

Энэ нь Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,204,145.6 мянган төгрөг болж 909,398.2 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлжээ.

3.4.2 Орлого бүрдүүлэлт

Сайнцагаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны орон нутгийн төсөв батлах тухай 35 дугаар тогтоолоор тус сум тайлант онд 5,241,855.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,756,948.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 9.8 хувиар давуулсан байна.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хүснэгт 2. Төлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

ОРЛОГЫН ТӨРӨЛ	Санхүүгийн тайлангаар		Татварын мэдээгээр		Гүйцэтгэл зөрүү	Хувь
	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц		
Үйл ажиллагааны орлого /ИОТГХ/	139,000.0	141,930.9	139,000.0	143,399.8	(1,468.9)	102.1
Халгаламжийн хүүгийн орлого	340,000.0	423,972.5	340,000.0	423,972.5	-	124.7
Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	120,000.0	154,826.0	120,000.0	154,826.0	-	129.0
Бууны албан татвар	3,880.0	3,930.0	3,880.0	3,870.0	60.0	101.3
Улсын тэмдэгтийн хураамж	28,200.0	26,647.4	28,200.0	26,647.4	-	94.5
Хог хаягдлын үйлчилгээ	122,400.0	91,288.7	122,400.0	99,092.9	(7,804.2)	74.6
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	55,000.0	-	55,000.0	-	-	0.0
Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	-	-	-	-	-	-
Газрын төлбөр	111,000.0	103,461.5	111,000.0	103,461.5	-	93.2
Малын тоо толгойн албан татвар	166,000.0	117,734.0	166,000.0	109,078.1	8,655.9	70.9
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	97,560.0	102,563.3	97,560.0	92,889.2	9,674.1	105.1
Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татвар	4,058,815.0	4,387,521.3	4,058,815.0	4,357,765.0	29,756.3	108.1
Татварын хүү торгууль	-	203,072.5	-	17,660.6	185,411.9	
	5,241,855.0	5,756,948.2	5,241,855.0	5,532,663.0	224,285.2	

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дараах орлогоуд материаллаг дүнгээр давж биелсэн байна. Үүнд:

- Цалин түүнтэй адилтгах орлогын албан татварын орлого 328,706.3 мянган төгрөгөөр давсан нь 2023 оны эхнээс орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн мөн хагас жилээр төрийн албан хаагчдын цалинг нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн орлогын албан татварын орлого 34,826.0 мянган төгрөгөөр давсан нь суманд шинээр үл хөдлөх хөрөнгүүд баригдсантай холбоотой байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 83,972.5 мянган төгрөгөөр давсан нь иргэдийн хадгаламж нэмэгдэж, хадгаламжийн хүү тооцож олгогдсонтой холбоотой байна.
- Хүү торгуулын орлого орлогын төлөвлөгөө батлагдаагүйгээс гүйцэтгэлээр давж биелсэн байна.

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна. Үүнд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр огт биелээгүй нь хууль, эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой байна.
- Малын тоо толгойн албан татвар 48,266.0 мянган төгрөгөөр тасарсан нь өмнөх жилийн дутуу татварыг төлөвлөгөөнд нэмж баталсантай холбоотой байна.
- Улсын тэмдэгтийн хураамж 1,552.6 мянган төгрөгөөр тасарсан нь ААНБ-ууд бүртгэгдээгүйтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сайнцагаан сумын ИТХ-ын 2022 оны 35 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 6,205,264.85 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 7,417,148.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Сайнцагаан сумын ИТХ-ын 2022 оны 35 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт тодотгол хийж, сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 06 дугаар сард төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 7,417,148.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 7,417,148.7 мянган төгрөг болгон ихэсгэж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 6 хөтөлбөрт зориулан 5,043,689.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,387,848.4 мянган төгрөгийг урсгал зардалд, 999,841.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 656,000.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 793,841.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, 3,450,848.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 503,500.0 мянган төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос, 295,500.0 мянган төгрөгийг урьд оны эхний үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 793,841.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 3,118,225.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 502,910.7 мянган төгрөг, урьд оны эхний үлдэгдлээс 277,108.2 нийт 4,692,085.5 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 406,231.6 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 43,768.4 мянган төгрөгөөр тасалж, туслах үйл ажиллагааны орлого 96,679.0 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 43,179.0 мянган төгрөгөөр биелсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нь Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлого, туслах үйл ажиллагааны орлогод мал хамгаалах, байгаль хамгаалах сангийн орлого, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,210,943.1 мянган төгрөг буюу 83.5 хувьтай байгаа нь урсгал зардал 332,178.3 мянган төгрөг, хөрөнгийн зардал 192,568.6 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээл 308,000.0 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 2,373,458.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсөв захирагчаас 22,326.6 мянга, хандив тусламжаар 50,000.0 мянга, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 9,663.8 мянга нийт 81,990.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 3,886.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 53,683.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 14,996.5 мянга, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардалд 3,150.0 мянга төгрөгийг зарцуулж, 6,274.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Сайнцагаан сумын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагчид эгзэгд түүний орчин аудитал хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ж.Угтахбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 04-ны өдрийн 02/85 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт зардал 6,590,710.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 98,860.6 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 69,202.5 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор урсгал зардал 332,178.3 мянган төгрөг, хөрөнгийн зардал 192,568.6 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээл 308,000.0 мянган төгрөгийг тус тус хэмнэн, батлагдсан төсвийг 83.5 хувийн хэрэгжилттэй зарцуулжээ.

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн зөрчсөн асуудал аудитын явцад илрээгүй болно. Аудитын явцад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой судалгааг авч санхүүгийн аудитын системд оруулсан.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг дарга нь 2023 онд нийт 372,545.6 мянган төгрөгийн 169 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулж, хэрэгжилт 100.0 хувь байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд завсрын аудит хийсэн байна. Төсөвт байгууллагуудын 2023 санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар ЗДТГ-т 7,818.7 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 22,730.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснээс зөрчлийг арилгаж, нотлох баримтыг ирүүлсэн байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 26,296.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага, 2,944.4 мянган төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1 заалт бүхий 1,860.2 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	2,944.4	5	2,944.4			100
Албан шаардлага	4	26,296.3	4	26,296.3			100
Зөвлөмж	1	1,860.2	1	1,860.2			100
Нийт	10	31,100.9	10	31,100.9			

Өмнөх аудитаар өгөгдсөн төлбөрийн актыг хугацаанд нь барагдуулж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн тухай хариуг Төрийн аудитын газарт албан бичгээр болон санхүүгийн тайлангийн аудитын “<https://fas.audit.mn/>” системээр ирүүлсэн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын шатахууны зарцуулалт, татварын орлого бүрдүүлэлт, үндсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 262,299.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 118,831.6 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 143,468.3 мянган төгрөгийн 1 хугацаатай албан шаардлага хүргүүлжээ.

Залруулсан алдаа:

Аудитаар нийт 118,831.6 мянган төгрөгийн 2 алдаа¹ илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогыг 54,417.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.
- Үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний зардлыг 64,414.3 мянган төгрөгөөр дутуу тайлагнасныг аудитын явцад залрууллаа.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт 143,468.3 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчил арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

- Нийт 11 нэр төрлийн татварын орлогоос 5 нэр төрлийн 143,468.3 мянган төгрөгийн татварын орлогыг батлагдсан төлөвлөгөөнөөс дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.19-т /Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т /Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1-т /Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/ заасныг тус тус зөрчсөн байна.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангшлаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А		2	3	4	5	7	8	9	10

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Дундговь аймгийн Сайнцагаан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1	Засаг даргын Тамгын газар	1	1			1	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1			
3	Мал хамгаалах сан	1		1			
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1			
5	Орон нутгийн хөгжлийн	1		1			
6	Байгаль хамгаалах сан	1		1			
НИЙТ		6	1	5		1	

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,035,996.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 429,957.9 мянган төгрөгийн 10 алдааг аудитын явцад залруулж, 15,459.9 мянган төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 590,578.2 мянган төгрөгийн 11 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэн, 1 зөрчилд зөвлөмж, 3 хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 58.5 хувийг залруулагдаагүй, 41.5 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 41,921.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшингээс 56,939.4 мянган төгрөгөөр буюу 57.6 хувиар бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитгаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл
Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

Алданы товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхин дууссан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан,		Үүнээс Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сайншагдан сумын Засаг даргын Тамгын газар	7	310,480.7			7	310,480.7	7	310,480.7		
Сайншагдан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	645.6			1	645.6	1	645.6		
Сайншагдан сумын Мал хамгаалах сан	2	118,831.6			2	118,831.6	2	118,831.6		
Сайншагдан сумын Байгаль хамгаалах сан	-	-			-	-	-	-		
Сайншагдан сумын Хоршоо хөгжүүлэх сан	-	-			-	-	-	-		
Сайншагдан сумын Орон нутгийн хөгжлийн	-	-			-	-	-	-		
Сайншагдан сумын Нэгтгэсэн санхүүгийн тайлан	-	-			-	-	-	-		
Дүн	10	429,957.9			10	429,958	10	429,958		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл:

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сайншагдан сумын Засаг даргын Тамгын газар	7	38,758.7	2	14,128.7	3.0	24,630.0			2			
Сайншагдан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	1,026.0	1	20.0	1.0	1,006.0						
Сайншагдан сумын Мал хамгаалах сан	-	-										
Сайншагдан сумын Байгаль хамгаалах сан	-	-										
Сайншагдан сумын Хоршоо хөгжүүлэх сан	1	1,311.2	1	1,311.2					1			
Сайншагдан сумын Орон нутгийн хөгжлийн	1	-										
Нэгтгэсэн санхүүгийн тайлан	-	-										
Дүн	11	41,095.9	4	15,459.9	4.0	25,636.0			3			

Үүнээс

/млн. төг/

Дундговь аймгийн Сайншаган сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Мян. төг

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1						1	
	Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
1	Сайншаган сумын Засаг даргын Тамгын газар	2	-			2			
2	Сайншаган сумын Орон нутгийн хөгжлийн	3	559,428.3			3	559,428.3		
3	Сайншаган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	2	5,513.9			2	5,513.9		
	Сайншаган сумын нэгтгэсэн санхүүгийн тайлан	1	143,468.3			1	143,468.3		
	Дүн	8	564,942			8	564,942		
	Нийт дүн	9	708,410.5	-		9	708,410.5		